



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2023 оны 02 сарын 10 өдөр

Дугаар 63

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168, Засгийн газрын 2022 оны 417 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын харьяа Дархан-Уул аймаг дахь Мэргэжлийн хяналтын газар (хуучин нэрээр)-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 30,800,000.00 (гучин сая найман зуун мянган) төгрөгийн балансын үнэ, 9,432,589.21 (есөн сая дөрвөн зуун гучин хоёр мянга таван зуун наян есөн төгрөг хорин нэгэн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газарт хавсралтад заасны дагуу балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Нямсүрэнд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

130021136
4-F huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн
6.3..... дугаар тогтоолын хавсралт



Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын харьяа Дархан-Уул аймаг
дахь Мэргэжлийн хяналтын газар /хуучин нэрээр/-ын үндсэн
хөрөнгөд бүртгэлтэй Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн
ерөнхий газарт балансаас балансад шилжүүлэх автомашины жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Үйлдвэрлэсэн ашиглалтад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	Тоёота Хайс, 0032 ДАУ	2011/ 2019	30,800,000.00	9,432,589.21	21,367,410.79
	Нийт дүн		30,800,000.00 (гучин сая найман зуун мянга)	9,432,589.21 (есөн сая дөрвөн зуун гучин хоёр мянга таван зуун наян есөн төгрөг хорин нэгэн мөнгө)	21,367,410.79 (хорин нэгэн сая гурван зуун жаран долоон мянга дөрвөн зуун арван төгрөг далан есөн мөнгө)